



“БӨХӨГ” ХК 2022 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<p><i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i></p>	
<p><i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/</i></p>	<p><i>2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр</i></p>
<p><i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i></p>	<p>“Бөхөг” ХК Регистрийн дугаар: 2038285 Үнэт цаасны код: BNG Утас: 91918811</p>
<p><i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i></p>	<p>Монголын хөрөнгийн бирж</p>
<p><i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i></p>	<p>Шувууны аж ахуй</p>
<p><i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i></p>	<p>“Аяа такс аудит” ХХК</p>
<p><i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i></p>	<p>457293 ширхэг</p>
<p><i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i></p>	<p>Гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг</p>
<p><i>1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i></p>	
<p>Санхүүгийн байдлын үзүүлэлт /тайлан хавсаргав/</p>	
<p>Эргэлтийн хөрөнгө 979,523,200.00</p> <p>Эргэлтийн бус хөрөнгө 2,366,010,800.00</p> <p>Нийт хөрөнгө 3,345,534,000.00</p>	<p>Нийт өр төлбөр 1,817,023,284.00</p> <p>Эздийн өмч 1,528,510,716.00</p> <p>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн 3,345,534,000.00</p>
<p>Орлогын тайлан</p>	
<p>Борлуулалтын орлого 16,800,000.00</p> <p>Ерөнхий ба удирдлагын зардал 62,307,384.00</p> <p>Татварын өмнөх ашиг /алдагдал/ (45,507,384.00)</p>	

Өмчийн өөрчлөлтийн тайлан /тайлан хавсаргав/		
Хувьцаат капитал	45,729,300.00	
Хуримтлагдсан ашиг	(479,591,884.00)	
Мөнгөн гүйлгээний тайлан /тайлан хавсаргав/		
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(34,362,244.00)	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	43,318,544.00	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,956,300.00	
1.1	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>	
2022 оны санхүүгийн тайлангийн хараат бус аудитаар Зөрчилгүй дүгнэлт гарсан.		
1.2	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>	
Удирдлагын захидал хавсаргав.		
2	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>	
2.1	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Өрийн харьцаа – 0,54 Мөнгөн хөрөнгийн харьцаа – 0,006
2.2	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт</i>	Эргэлтийн харьцаа – 0,54 Түргэн хөрвөх чадварын харьцаа – 0,039
2.3	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт хөгжил дээх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	2023 оны ээлжит хурлаар хөрөнгө оруулалт, санхүүжилт татах талаар ир хэмжээний хэлцлийн талаар хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, мэдээлэл өгсөн.
2.4	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	Тайлант хугацаанд хүүтэй зээл аваагүй, зээлийн барьцаа, баталгаа гаргаасгүй.
3	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	

4	Цалин урамшууллын мэдээлэл	
	Цалин урамшуулал олгоогүй.	
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Холбогдох хууль журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, хуралд оролцох, мэдээлэл авах, санал өгөх зэргийг хэрэгжүүлсэн.	
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	
	Одоогоор үйл ажиллагаа эрхээгүй байгаа ч 2023 онд хөрөнгө оруулалт, санхүүжилт татахад анхаарч ажиллана.	
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	
	Ц.Чанцал – 302213 ширхэг Ц.Ганцэцэг – 119210 ширхэг Үндэсний хувьчлалын сан хамтын хос – 6077 ширхэг Higger Thomas Eugen – 5725 ширхэг Ц.Түдэв – 1400 ширхэг Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо - 230	
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
	Нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.	
9	Ногдол ашгийн мэдээлэл	
	ТУЗ-ийн 2023 оны 03 сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор ногдол ашиг хуваарилах боломжгүй.	
10	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл	
	Нийгмийн хариуцлагын чиглэлээр ажил хийгдээгүй.	
	Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог нэр: Цогт Ганцэцэг “Бөхөг” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг:  (Тамга/тэмдэг)	Овог нэр: “.....” ХХК-ийн аудитийн компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг:..... (Тамга/тэмдэг)
	Мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
	Овог нэр: М.Билгүүнзаяа	
	Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	
	Гарын үсэг: 	



АЯА ТАКС АУДИТ ХХК

Улаанбаатар хот, СБД, I хороо, V хороолол,
14251, Чингисийн өргөн чөлөө 19-Б Бизнес

таур 11 давхар Утас: 99994447, 98658500

2023.03.21 № 23/

Танай _____ -ны № 07 -т

БӨХӨГ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
БОЛОН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид БӨХӨГ ХК-ий 2022 оны 12 сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр Аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг тайлант оны байдлаар авч үзэж дүгнэлт гаргасан болно.

а/ Бараа материалын үнэлгээ

Удирдлага удаан гүйлгээтэй болон хуучирсан бараа материалын хасагдуулгыг тодорхойлохдоо үлэмж хэмжээний төсөөлөл болон үнэлэмж ашигладаг учраас бид бараа

материалын үнэлгээг аудитын гол асуудал гэж үзсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогоор бараа материалын үнэлгээг тооцохдоо бараа материалын насжилт дээр үндэслэн өмнөх жилүүдийн туршлага, түүхэн мэдээлэлд үндэслэн тооцсон алдагдлын хувийг ашиглан тооцдог.

Бараа материалын үнэлгээтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- ✚ Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо ашигласан удирдлагын үнэлгээ болон бараа материалыг тэдгээрийн цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл залруулж, бараа материалын сан байгуулах дотоод горимыг судлах, ойлгох;
- ✚ Борлуулалтын түүхэн мэдээ, өнөөгийн зах зээлийн орчин, маркетинг болон урамшууллын төлөвлөгөө, бараа материалын насжилт болон бараа материалын борлуулалтын үнэ зэрэгт үндэслэн бараа материалын хасагдуулга нь зохистой эсэхийг үнэлэх;
- ✚ Түүврийн аргаар бараа материалын насжилтыг холбогдох анхан шатны баримттай нь тулгаж шалгах;
- ✚ Түүврийн аргаар бараа материалын борлуулалтын үнийг холбогдох анхан шатны баримттай тулгаж шалгах.

Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

б/ Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдал

- ✚ Удирдлагын авлагыг тооцоолдог горимыг судлах, ойлгох;
- ✚ Төлөгдөөгүй авлагын үлдэгдэлд байж болох боломжит эрсдлийн хэмжээг тооцоолох болон ойлгох зорилгоор түүврийн аргаар дансны ба бусад авлагын насжилтыг холбогдох анхан шатны баримтуудтай нь тулгаж шалгах;
- ✚ Төлөгдөх хугацаа нь 60 хоногоос хэтэрсэн авлагууд нь даатгагдсан эсэхийг үнэлэхийн тулд даатгалын гэрээтэй нь тулгах, тайлант хугацааны дараа цуглуулагдсан дүнгүүдийг шалгах. Даатгагдаагүй авлагуудын хувьд, тухайн харилцагчдийн өмнөх жилүүдийн төлбөр төлсөн байдал зэрэгт үндэслэн найдваргүй авлагын хасагдуулга нь зохистой эсэхийг үнэлэх;
- ✚ Тайлант хугацааны дараа цуглуулагдсан авлагыг холбогдох баримтуудтай тулгах;
- ✚ Түүврийн аргаар өмнөх жилүүдэд удирдлагын тооцоолсон найдваргүй авлагын хасагдуулга нь зохистой байсан эсэхийг төлөгдсөн авлага, бодит найдваргүй авлагын зардлыг холбогдох анхан шатны баримтуудтай нь тулган баталгаажуулах.

в/ Татварын тооцооллын үнэн, зөв байдал

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар

бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс шалтгаалсан татварын эрсдэл байсаар байна.

Татварын тооцооллын үнэн зөв, зохистой байдлыг үнэлэхтэй холбоотой бидний гүйцэтгэсэн горимууд:

- ✚ Татварын тооцоолол ба түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого болон татварын талаарх удирдлагын байр суурь, үнэлгээг судлах, ойлгох;
- ✚ Татварын хууль, журам дүрэм болон практик туршлагатай өөрсдийн татварын мэргэжилтнүүд болон Компани ба эрх бүхий татварын албадууд хоорондын харилцааг ашиглан санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөрүүд нь зохистой эсэх, эсвэл татварын өр төлбөрийг бүртгээгүй үндэслэл шалтгааныг үнэлэх;
- ✚ Санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын өр төлбөр болон тодруулга нь хангалттай эсэх, уг өр төлбөр нь татварын хуулийн сүүлийн өөрчлөлтүүдийн дагуу тооцоологдсон эсэх, боломжит татварын торгууль болон хүүг агуулсан эсэхийг үнэлэх.

Бусад мэдээлэл

Энэхүү санхүүгийн тайланд өгөх манай дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид дээр тодорхойлогдсон бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд бид бусад горимыг гүйцэтгэж, дараах зүйлсийг тодорхойлно:

- ✚ Бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний алдаатай эсэх;
- ✚ Санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай эсэх; эсвэл
- ✚ Түүний орчны талаарх бидний ойлголтыг шинэчлэх хэрэгтэй эсэх.

Хэрэв бид бусад мэдээлэлд материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг нь залруулаагүй бол, бид залруулагдаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд зохистой арга хэмжээ авахыг холбогдох эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв бид аудитлагдсан санхүүгийн тайлан болон түүний орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээг авна.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлагын эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг


Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

Бусад хууль эрх зүйн шаардлагуудын талаарх тайлан

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92 болон 94-р зүйлийн дагуу бид дараах тохиолдлуудад та бүхэнд тайлагнах үүрэгтэй:

- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ;
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалттай холбоотой зөрчил;
- Компанийн дүрмийн дагуу болон аудитын гэрээний дагуу шаардагдах бусад мэдээлэл

Дээрх зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.


Я.Аюушжав
Захирал
Аяа Тах Аудит ХХК
2023 оны 3-р сарын 21

“БӨХӨГ” ХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(төгрөг)

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /ХУРААНГУЙ/			
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2021.12.31-ний үлдэгдэл	2022.12.31-ний үлдэгдэл
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,540,600.00	11,496,900.00
2	Дансны авлага	60,690,800.00	60,690,800.00
3	Бараа материал	141,057,100.00	141,057,100.00
4	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	766,278,400.00	766,278,400.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	970,566,900.00	979,523,200.00
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
5	Үндсэн хөрөнгө	2,366,010,800.00	2,366,010,800.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,366,010,800.00	2,366,010,800.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,336,577,700.00	3,345,534,000.00
	ӨР ТӨЛБӨР		
6	Дансны өглөг	656,499,500.00	708,911,278.00
7	Цалингийн өглөг	26,090,600.00	26,090,600.00
8	Татварын өр	164,487,800.00	165,387,706.00
9	НДШ-ийн өглөг	2,265,600.00	3,417,600.00
10	Богино хугацаат зээл	79,491,700.00	79,491,700.00
11	Богино хугацаат өр төлбөр	833,724,400.00	833,724,400.00
	Өр төлбөрийн нийт дүн	1,762,559,600.00	1,817,023,284.00
	ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
12	Хувьцаат капиталын дүн	45,729,300.00	45,729,300.00
13	Эздийн өмч бусад хэсэг	1,962,373,300.00	1,962,373,300.00
14	Хуримтлагдсан ашиг:	(434,084,500.00)	(479,591,884.00)
	Эздийн өмчийн дүн	1,574,018,100.00	1,528,510,716.00
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,336,577,700.00	3,345,534,000.00
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /ХУРААНГУЙ/			
1	Борлуулалтын орлого (цэвэр)		16,800,000.00
2	Борлуулалсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг /алдагдал/	-	16,800,000.00
4	Ерөнхий ба удирдлагын зардал		62,307,384.00
5	Бусад ашиг (алдагдал)		
6	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	(45,507,384.00)
7	Орлогын татварын зардал		
8	Татварын дараах ашиг (алдагдал)	-	(45,507,384.00)
9	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
10	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	(45,507,384.00)